

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2022 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2011 оны 311, 2022 оны 246 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай байлгах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй


Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3, 6, 9 дүгээр зүйлийг үндэслэж үнэлсэн болно.

- "Бүрэн хэрэгжсэн"- холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- "Хэрэгжих шатанд"- тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь);
- "Хэрэгжилт хангалтгүй"- тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь);
- "Хэрэгжээгүй"- тухайн зорилтыг хэрэг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалдаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-10 хувь);

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Тайлангийн биелэлтийг цаасан болон цахим суурьтай хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 41 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд;

1. Бүрэн хэрэгжсэн 100 хувийн гүйцэтгэлтэй 34 арга хэмжээ
2. Хэрэгжих шатанд 70 хувийн гүйцэтгэлтэй 6 арга хэмжээ
3. Хэрэгжилт хангалтгүй 30 хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ



Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэлгээ	Шалтгаан
1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	30	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам"-ыг боловсруулан ажиллаж байна.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтийг журамд нийцүүлэн үнэлэхэд үнэлгээний дундаж 88.67 хувийн гүйцэтгэлтэй буюу "хэрэгжих шатанд" гэж дүгнэж байна.

Зургаа. Цаашид анхаарах асуудал

1. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт /*эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн*/, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3.4 дэх заалт /*стратегийн төлөвлөгөөний биелэлт*/ заасны дагуу стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг боловсруулан тайлагнаагүй байна.

2. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт /*чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг*/, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 1.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын чиг үүргийг дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хаягт байршуулан ажиллаагүй байна.

3. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт /*албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам*/, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт

захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 2.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хаягт байршуулаагүй байна.

4. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт */хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам/*, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу "Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам"-ыг боловсруулж батлуулаагүй байна.

5. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.26 дахь заалт */төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн/*, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 3.13-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг тайлагнаагүй байна.

6. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалт */олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал/*, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 5.1-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгааг олон нийтээр хэлэлцүүлж санал аваагүй, дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хаягийн хууль эрх зүйн буланд мэдээллийн хөгжүүлэлт хангалтгүй байна.

7. Монгол улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт */төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл/*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь заалт */Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна/*, Засгийн газрын 2001 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 49 дүгээр тогтоол, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтын 5.7-т заасны дагуу мэдээллийг бүрэн тайлагнаагүй байна.

Тав. Зөвлөмж

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлын биелэлтийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний хэрэгжилтийг хоёр мянган тэмдэгтэд багтаан албан хэрэг хөтлөлтийн стандарт дүрмийг мөрдөж, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах;

2. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, ойлгомжтой, үнэн зөв, бүрэн харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй, нээлттэй байлгах;

3. Хэлтэс, албад үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй байдлыг хангаж, чиг үүргийн дагуу www.chingeltei.gov.mn цахим хаягт байрлах өгөгдлийг цаг тухай бүр шинэчилж байх;

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН
ГАЗРЫН ДАРГА



П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

A blue ink signature of N. Naranzul.

Н.НАРАНЗУЛ

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

A blue ink signature of N. Enkhgerel.

Н.ЭНХГЭРЭЛ